

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Тайлангийн дугаар: 01

Байгууллагын нэр: БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

Аудитын хамрах хүрээ: Барилга, хот байгуулалтын яам

Огноо: 2022.11.08

Зорилго: Барилга, хот байгуулалтын яамны ЧМТ-ны стандартыг хэрэгжүүлэх явцад сайжруулах боломжийг тодорхойлох, үр нөлөөг үнэлэх.

Шалгуур: ISO 9001:2015 стандарт

1. Тайлан

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022.11.28-ны өдрийн А/162 дугаар тушаалаар 10 гишүүнтэй ажлын хэсэг байгуулагдан 2022.11.08 -2023.02.28-ны өдрүүдэд дотоод аудит хийсэн.

Дотоод аудитыг чанарын менежментийн тогтолцооны стандартын дагуу аудитын шалгах хуудсыг 7 бүлгийн 109 шалгуур үзүүлэлтийн асуумжаар мэдээлэл цуглуулах, баримт материалын үзлэг шалгалт хийх, ярилцлага, ажиглалтын аргаар хийсэн.

Аудит хийх явцад нийт албан хаагчдын харилцаа хандлага сайн байж шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан.

Нийт 109 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн ба үүнээс шаардлага хангасан 85 , сайжруулах шаардлагатай 13, шаардлага хангаагүй 11 үр дүн гарсан.

2. Аудитын явцад ажиглагдсан сайн талууд:

- Шинээр гарсан дүрэм журмын өөрчлөлтийг цаг тухайд нь ERP системд мэдээлж байна;
- Ажлын байранд мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн байна;
- Яамны интернэтийн хурд хэмжигч байршуулж, хэмжилт хийсэн байна;
- Сайдын багцын Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд Shilendans.gov.mn сайтад байршуулсан байна;
- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд жил, улирлаар хяналт тавьж үнэлгээ хийж хэвшсэн байна;
- Байгууллагын цахим хуудас, мэдээллийн системийн хандалтын судалгаа хийсэн байна;
- Дотоод аудит хийх аргачлал, журам, батлагдсан төлөвлөгөөтэй байна;
- Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлснээр 5S стандартыг хэрэгжүүлж яамны өрөө тасалгаанд засвар үйлчигээ хийж ажиллах орчныг сайжруулсан байна;
- Ямар нэгэн үйл ажиллагаа зохион байгуулахад удирдлагын оролцоо, дэмжлэг сайн байна;

3. Аудитын явцад үл тохирол илэрсэн байдал:

- 6.1.4. Байгууллагын эрсдлийг бууруулах төлөвлөгөө байхгүй;
- 6.1.11.Эрсдэлээс сэргийлэх боломжийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоогүй байна;
- 6.2.6.Чанарын менежментийн төлөвлөгөөнд юу хийх, ямар нөөц шаардлагатай хэн хариуцах хэзээ дуусгах, үр дүнг хэрхэн үнэлэх талаар тусгаагүй байна;

- 8.2.2. Утсаар, цахимаар хандсан хэрэглэгчдэд үйлчилсэн тухайгаа бүртгэл хөтөлж хэвшээгүй байна;
- 8.3.1. Байгууллагын брэндбүүк байхгүй;

4. Сайжруулах санал:

- 4.4 Үйл явцын алхамыг тодорхойлох ✓
- 6.1.4. Байгууллагын эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг 2-3 жилээр урьдчилан төлөвлөх; ✓
- 6.1.5. Санал хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг яамны мэдээллийн самбар болон Вэб сайтад байршуулж хэвших; ✓
- 7.1 Шинээр батлагдсан журмууд, боловсруулсан баримт бичгүүдийг нийт ажилтнуудад танилцуулах сургалт хийх ✓
- 7.1.1. Яамны үүдэнд хэдэн давхарт яам байдаг, газар хэлтсүүд хэд хэдэн тоот өрөөнд байгаа талаар мэдээллийн самбар байршуулах; ✓
- 7.1.2. Өрөөнүүдийн үүдний хаягт тухайн өрөөнд байгаа ажилтнуудын нэрсийг тодорхой бичих; ✓
- 7.1.6. Ажилтнуудыг сүүлийн үеийн компьютер техник хэрэгсэл, гадуур ажлаар явахад зориулсан зөөврийн компьютерээр хангах; ✓
- 7.1.12. Гадаад дотоодын сургалтад хамрагдсан албан хаагчид сургалтын тайлан мэдээллийг албан хаагчдад мэдээллийн цагаар танилцуулдаг байх; ✓
- 7.2.2. Ур чадварын үнэлгээний судалгааны дүнд үндэслэн албан хаагчдыг хамруулах сургалт хөгжлийн төлөвлөгөө гаргаж удирдлагаар батлуулах; ✓
- 7.3.1. Бүх албан хаагчдад байгууллагын эрхэм зорилго, чанарын бодлого зорилтыг танилцуулж мэддэг болгох; ✓
- 8.2 Хуулийн нийцлийн үнэлгээ хийх
- 9.3.7. Дотоод аудиторын багийн дүгнэлтийн дагуу Чанарын менежментийн тогтолцоог сайжруулах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, чанарын удирдлагын багийн ажлыг тогтмолжуулах; ✓

5. Дотоод аудиторын дүгнэлт: ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ДОТООД АУДИТЫН ШААРДЛАГА ХАНГАЖ БАЙНА.

ТАЙЛАН БИЧСЭН: АХЛАГЧ *[Signature]* /Л.ИДЭРЦОГТ/
 ГИШҮҮН *[Signature]* /Н.НАРАНТУЯА/
[Signature] /С.ДОЛЖИНСҮРЭН/
[Signature] /Ц.УУГАНБАЯР/
[Signature] /Д.ГЭРЭЛМАА/
[Signature] /С.АРИУНЦЭЦЭГ/
[Signature] /Б.ГАНДОЛГОР/
[Signature] /Э.АРИУННЯМ/
[Signature] /Э.УСАНБОЛОР/
[Signature] /Д.ГАНТУЯА/

ОГНОО: 2023.03.03

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:/ ТЗУГ-ын дарга Д.Баярсайхан/